

## АЖИЛД УРЬЖ БАЙНА

Хүүхдийг Ивээх Сан (Япон) нь хүүхдийн төлөөх олон улсын томоохон байгууллагуудын нэг бөгөөд бид хүүхдийг хамгаалж, хүүхдийн эрхийг цогцоор нь болон эсэн мэнд амьдрах эрхийг хангахын төлөө тэмцэж, хүүхдийг өөрт байгаа боломж бололцоогоо бүрэн дүүрэн ашиглахад тусалдаг. ХИС нь 1994 оноос хойш Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд боловсрол, хүүхэд хамгааллын чиглэлээр голчлон ажиллаж байна.

Хүүхдийг Ивээх Сан (ХИС) нь Японы Гадаад хэргийн яамны санхүүжилттэйгээр 3 жилийн хугацаанд хэрэгжих "Монгол улсад хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь" төслийн хүрээнд Өвөрхангай аймагт ажиллах **төслийн туслах ажилтны ажлын байр** зарлаж байна (Ажлын туршлага, үр чадвар, гүйцэтгэл зэргийг харгалзан жил бүр гэрээг сунгана).

**Энэхүү төслийн гол зорилго** нь Улаанбаатар хотын 3 дүүрэг болон Ховд, Өвөрхангай аймгийн хүүхэд бүрийг хүртээмжтэйгээр боловсролд тэгш хамруулахад дэмжлэг үзүүлж, дараах үр дүнд хүрэхээр зорьж байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуулиудад тэгш хамруулан сургах боловсролын тогтолцоог бүрдүүлэх,
- Насан туршийн боловсролын төвд суурилан сурагчдыг сургуульд нь буцаан оруулж, шилжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд үндсэн тогтолцоог нь сайн бүрдүүлж, сургуульд хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдэд хүрч ажиллах,
- Эдгээр хүчин чармайлтыг олон нийтээр дэмжүүлэхийн тулд эцэг эх, боловсролын ажилтнуудын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх,
- Гарсан үр дүндээ үндэслэн бодлого боловсруулагчдад зориулсан зөвлөмж гаргана.

**Гүйцэтгэх ерөнхий үүрэг:** Орон нутгийн төслийн туслах ажилтан нь Өвөрхангай аймагт хэрэгжих төслийг ерөнхийд нь хариуцах ба ХИС болон санхүүжүүлэгч байгууллагын дүрэм, журмын дагуу Төслийн зохицуулагчийн удирдлага доор ажиллана. Энэхүү ажлын байранд бүтээлч, санаачилгатай, идэвхтэй ажиллах хувь хүнийг сонгон шалгаруулах ба доорх үүргүүдийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Төслийн орон нутагт хэрэгжих үйл ажиллагааны жилийн болон улирлын төлөвлөгөөг гарган төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн дагуу төслийн үйл ажиллагааг зохион байгуулах (уулзалт, хурал, сургалт семинар зэргийг зохион байгуулах, мэдээлэл цуглуулах, солилцох, түгээх, тайлагнах, хяналт тавих гэх мэт),
- Төслийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд орон нутгийн байгууллагууд, зорилтот бүлэг, олон нийттэй үр дүнтэй ажиллах ба Улаанбаатар дахь ХИС-гийн ажилчдыг холбон хамтран ажиллах,
- Төслийн хэрэгжилтийн тайланг цаг хугацаанд нь гаргах ба шаардлагатай үед сум, орон нутгаар томилолтоор явах, төслийн хэрэгжилтэд байнгын хяналт тавих,
- Төслийн зохицуулагчийн удирдлага дор төслийн багаас оногдуулах бусад үүргүүдийг (захиргааны болон логистикийн ажлууд) гүйцэтгэнэ.

### **Төслийн туслах ажилтанд тавигдах шаардлага**

- Хүүхдийг Ивээх Сангийн зорилго, зорилт, алсын харааг хүлээн зөвшөөрч, хүндэтгэн ажиллах хүсэлтэй,
- Боловсролын болон нийгмийн ажилтны чиглэлээр мэргэшсэн, бакалавр болон түүнээс дээш түвшний боловсролтой,
- Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай,
- Хүүхэд, багачууд болон өсвөр насны хүүхдүүдтэй ажиллаж байсан туршлагатай,
- Баримт бичиг боловсруулах, тайлагнах чадвартай, төсөл хөтөлбөр дээр ажиллаж байсан бол давуу тал болно,
- Багаар ажиллах, чиглүүлэх, сургалт зохион байгуулах үр чадвартай,
- Англи хэлний ярианы болон бичгийн үр чадвартай,
- Харилцааны болон хувийн зохион байгуулалт, цагийн менежемент сайтай, ажлын ачаалал даах чадвартай,
- Хөдөө, орон нутагт томилолтоор ажиллах боломжтой,
- Компьютерийн Excel, Word, Outlook болон өдөр тутмын бусад програмуудыг сайн эзэмшсэн байх,

### **Бүрдүүлэх материал**

Хэрэв та ХИС-гаас зарласан дээрх ажлын байрыг сонирхож, дээр дурдсан шаардлагуудад нийцэж байвал ажилд орох өргөдөл (англи хэл дээр), төрийн албан хаагчийн анкет (1 хувь зурагны хамт), их, дээд сургууль төгссөн дипломны хуулбар, одоо ба урьд нь ажиллаж байсан албан байгууллагын ажил байдлын талаарх 3 хүний тодорхойлолт (тодорхойлолт нь тамга тэмдэгтэй, албан ёсны байх) зэргийг бүрдүүлж, **2018 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 17.00 цаг** хүртэл Хүүхдийг Ивээх Сангийн дор дурдсан имэйл хаягаар ирүүлнэ үү. **ХИС-д өгсөн материалыг буцааж олгохгүй.**

**Жич:** Эхний шатны шалгаруулалтад тэнцсэн хүнийг ярилцлагад дуудна.

Японы Хүүхдийг Ивээх Сан  
Улаанбаатар,  
Чингэлтэй дүүрэг, 1 хороо  
Аризона төв, 4 давхар  
Утас: 329365-17

**Имэйл хаяг:** [mongolia.secretary@savethechildren.org](mailto:mongolia.secretary@savethechildren.org);